118009	3.1.01.1.1.8.1.08	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	800,000.00	850,000.00
1181	3.1.01.1.1.8.2	Газрын төлбөр	8,100,000.00	10,603,357.00
118101	3.1.01.1.1.8.2.01	Газрын төлбөр	8,100,000.00	10,603,357.00
1182	3.1.01.1.1.8.3	Байгалийн нөөц ашигласны төлбөр	11,716,400.00	10,870,453.00
118201	3.1.01.1.1.8.3.01	Ойн нөөц ашигласны төлбөр	11,716,400.00	10,870,453.00
12	3.1.01.1.2	Татварын бус орлого	1,607,772,200.00	1,544,696,885.00
120	3.1.01.1.2.1	Нийтлэг татварын бус орлого	143,900,000.00	86,090,029.00
120003	3.1.01.1.2.1.3	Торгуулийн орлого	20,000,000.00	4,429,271.00
120004	3.1.01.1.2.1.4	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	123,900,000.00	81,186,701.00
120009	3.1.01.1.2.1.9	Бусад орлого	-	474,057.00
122	3.1.01.1.2.3	Тусламжийн орлого	1,255,235,400.00	1,255,235,400.00
122003	3.1.01.1.2.3.3	Аймаг нийслэлээс авсан татаас	1,255,235,400.00	1,255,235,400.00
122005	3.1.01.1.2.3.5	Төсвөөс санхүүжих		
123	3.1.01.1.2.4	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	208,636,800.00	203,371,456.00
123002	3.1.01.1.2.4.2	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	208,636,800.00	203,371,456.00
II	3.1.01.2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР		
	ЗЭЭЛИЙН ДҮН		2,712,332,600.00	2,352,954,715.83
21	3.1.01.2.1	УРСГАЛ ЗАРДАЛ	2,704,832,600.00	2,347,564,715.83
210	3.1.01.2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,171,315,600.00	2,148,789,715.83
2101	3.1.01.2.1.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,103,500,900.00	1,116,936,695.53

210101	3.1.01.2.1.1.1.01	Үндсэн цалин	1,021,024,800.00	691,482,487.89
210102	3.1.01.2.1.1.1.02	Нэмэгдэл	-	367,306,826.39
210103	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	-	24,098,000.00
210104	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	50,108,800.00	21,811,065.25
210105	3.1.01.2.1.1.1.05	Гэрээт ажлын хөлс	32,367,300.00	12,238,316.00
2102	3.1.01.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,986,900.00	138,986,199.59
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	94,522,400.00	101,807,798.50
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	11,117,000.00	10,112,500.00
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	5,558,400.00	-
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	5,558,400.00	4,379,700.00
210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	22,230,700.00	22,686,201.09
2103	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	751,904,000.00	746,293,910.71
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	100,788,300.00	97,514,632.60
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	626,440,100.00	625,842,375.43
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	24,675,600.00	22,936,902.68
2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	52,763,900.00	38,964,240.00
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	2,685,200.00	1,685,550.00
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	46,027,100.00	33,715,190.00
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,876,000.00	2,638,500.00
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	815,600.00	565,000.00
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	40,789,800.00	36,436,300.00
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	9,410,000.00	5,160,000.00
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	31,379,800.00	31,276,300.00

2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	9,881,000.00	9,054,600.00
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	9,881,000.00	9,054,600.00
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,329,100.00	5,576,710.00
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,179,100.00	300,500.00
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	622,000.00	-
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	280,000.00	276,210.00
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	308,000.00	-
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	-
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,520,000.00	5,000,000.00
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	2,332,000.00	-
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	63,160,000.00	56,541,060.00
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	45,338,000.00	39,421,960.00
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,822,000.00	17,119,100.00
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,500,000.00	5,390,000.00
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	-
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	7,500,000.00	5,390,000.00
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,500,000.00	5,390,000.00
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	413,517,000.00	178,775,000.00
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	413,517,000.00	178,775,000.00
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000,000.00	20,000,000.00
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	120,000,000.00	20,000,000.00
8	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	162,400,000.00	198,910,797.64
9	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 162,400,000.00	198,910,797.64

7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 162,400,000.00	- 198,910,797.64
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	243,030,163.13
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	641,525,960.77
6	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	78.00	78.00
61	6.1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	6.1.01	Төсвийн байгууллага	2.00	2.00
62	6.2	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36.00	33.00
620001	6.2.01	Удирдах ажилтан	14.00	14.00
620002	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	6.2.03	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	6.2.04	Гэрээт ажилтан	8.00	5.00

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	308,005,391.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308,005,391.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	308,005,391.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	308,005,391.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	308,005,391.00
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	201,585,000.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,420,391.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	107,946,834.00
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	13,044,684.00

210	1.1.1.2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,044,684.00
2104	1.1.1.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	6,249,500.00
210402	1.1.1.2.1.1.4.2	Тээвэр, шатахуун	6,249,500.00
2106	1.1.1.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	1,718,500.00
210602	1.1.1.2.1.1.6.2	Тавилга	1,018,500.00
210604	1.1.1.2.1.1.6.4	Урсгал засвар	700,000.00
2109	1.1.1.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	5,076,684.00
210901	1.1.1.2.1.1.9.1	Бараа үйлчилгээний бусад зардал	3,076,684.00
210902	1.1.1.2.1.1.9.2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00
22	1.1.1.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94,902,150.00
2200	1.1.1.2.2.1	Дотоод эх үүсвэрээр	94,902,150.00
223001	1.1.1.2.2.1.4	Бусад хөрөнгө	94,902,150.00
4	1.1.1	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	200,058,557.00
5	1.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 200,058,557.00
6	1 өөрчлөлт	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 200,058,557.00
10	3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлж, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Бусад

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Төрийн албаны тухай хуульд - 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгтгэл тайланд хамрагдсан байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 641.5 сая төгрөг болж, өмнөх оноос 398.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Хувь
Төрийн сангийн харилцах	243.0	641.5	398.5	163.9
Дүн	243.0	641.5	398.5	163.9

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 641.5 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 425.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 155.5 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 60.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 237.4 сая төгрөг болж 40.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	0.0	0.0	0.0
Хувь хүмүүсээс авах авлага	0.3	0.0	-0.3
Байгууллагаас авах авлага	103.8	486.0	382.2
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	133.3	155.5	22.2
Дүн	237.4	641.5	404.1

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өсөхөд Хоршоо хөгжүүлэх сангаас 20.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх зээл гаргасан, Тэс сумын ЗДТГ-ын наадмын талбайн үлдэгдэл санхүүжилт оны эцэст орж ирснээс шалтгаалан гүйлгээ хийгдээгүйн улмаас үүссэн авлага голчлон нөлөөлсөн байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл 99.7 сая төгрөг болж 2.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	0.0	0.0	0.0
Бичиг хэргийн материал	0.6	0.3	-0.3
Аж ахуйн материал	13.4	14.8	1.4
Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	0.0
Түлш шатах тослох материал	0.0	0.0	0.0
Барилгын засварын материал	0.0	0.2	0.2
Хүнсний материал	0.0	0.0	0.0
Бусад хангамжийн материал	27.2	28.5	1.3
Мал амьтад	55.8	55.8	0.0
Дүн	97.1	99.7	2.6

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл өсөхөд Засаг даргын тамгын газрын бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 6,446.7 сая төгрөг болж 120.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	5,061.1	5,347.0	285.9
Хуримтлагдсан элэгдэл	-802.2	-1,034.9	-232.7
Авто тээврийн хэрэгсэл	550.6	550.6	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-126.1	-198.6	-72.5
Машин тоног төхөөрөмж (компьютер)	507.3	512.4	5.1
Хуримтлагдсан элэгдэл	-202.5	-233.6	-31.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	59.4	60.4	1.0
Хуримтлагдсан элэгдэл	-49.3	-51.2	1.9
Зам, гүүрний байгууламж	1,442.7	1,442.7	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-72.1	-144.2	-72.1
Бусад үндсэн хөрөнгө	21.3	21.3	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-7.3	-9.0	1.7
Ном	118.9	118.9	0.0

Программ хангамж	1.5	1.5	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-1.5	-1.5	0.0
Бусад биет бус хөрөнгө	64.9	64.9	0.0
Дүн	6,566.8	6,446.7	-120.1

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,446.7 сая төгрөг болж 120.1 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 424.8 сая төгрөг болж 399.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбоотой өглөг	0.0	0.0	0.0
Байгууллагад төлөх өглөг	11.8	424.8	399.9
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	0.0	0.0
Татварын өглөг	0.0	0.0	0.0
НДШ өглөг	0.0	0.0	0.0
Нийт дүн	11.8	424.8	399.9

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 411.7 сая төгрөгөөр өссөн нь Тэс сумын ЗДТГ-ын наадмын талбайн үлдэгдэл санхүүжилт оны эцэст орж ирснээс шалтгаалан гүйлгээ хийгдээгүй, Эрүүл мэндийн газрын халаалтын өр төлбөр үүссэнээс шалтгаалсан байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,178.9 сая төгрөг болж 46.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	485.3	485.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	5,940.5	5,986.9	46.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	706.7	706.7	0.0
Дүн	7,132.5	7,178.9	46.4

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,178.9 сая төгрөг болж 46.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 1,007.2 сая, татварын бус орлого 85.6 сая, нийт 1,092.8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой 327.1 сая төгрөгийн 2 зөрчил илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Тэс сумын Засаг даргын тамгын газар:

Тэс сумын Засаг даргын тамгын газар нь Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолыг зөрчиж 2025 онд тээвэр шатахууны зардлаас 28.0 сая төгрөгөөр шатах тослох материалын шууд худалдан авалт хийсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

Тэс сумын ИТХ:

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 299.1 сая төгрөгийн зарлагын 35 мөнгөн гүйлгээг хугацаа хоцроосон, байгууллагын хөрөнгийн зарцуулалтай холбоотой төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг байршуулаагүй зөрчилд зөвлөмж өгсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 5/01 дүгээр тогтоолд Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 999.2 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 1,128.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 129.6 сая төгрөг буюу 112.9 хувиар биелүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,255.2 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 208.6 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 123.9 сая, сумын төсвийн урьд оны давсан орлогоос 162.4 сая, татварын болон татварын бус орлогоос 962.2 сая, нийт 2,712.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тэс сумын 2025 оны төсвийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 2/05 дугаар тогтоолоор 3,037.5 сая төгрөгөөр баталж, 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 5/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 325.5 сая төгрөгөөр бууруулж 2,712.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,712.3 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 1,255.2 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 208.6 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 123.9 сая, сумын төсвийн урьд оны давсан орлогоос 162.4 сая, татварын болон татварын бус орлогоос 962.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр татварын орлого 1,007.2 сая, татварын бус орлого 4.4 сая, төсөвт байгууллагын өрийн орлого 81.2 сая, бусад орлого 0.4 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 203.4 сая, аймгаас авсан татаас тусламжийн орлого 1,255.2 сая, нийт 2,551.8 сая төгрөгийн эх үүсвэр тайлант онд бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,352.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Зөрүү 198.9 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 201.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6.4 сая, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 100.0 сая, нийт 308.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 107.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,958.7 сая төгрөгийн 1 хувь буюу 49.6 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 39.7 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 643,461.9 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 189,163.2 мянган төгрөгийн 19 мэдээлэл байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 1 зөвлөмж өгсөн биелэлтийг 100% хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/16 дугаар захирамжаар Тэс сумын Засаг даргын Тамгын газрыг 19 орон тоотойгоор баталсан байна. Тэс сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Тэс сумын Засаг даргын Тамгын газрын орон тоог 4 гэрээт ажилтнаар нэмэгдүүлэн баталсан байна. Тоймлон дурдвал, слесарь болон 1 сахиулыг төрийн үйлчилгээний албан тушаалын цалин хөлсөөр, 3 багийн сахиулыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан ажиллуулсан байна. Дараагийн аудитаар бүтэц, орон тоог нягтлан шалгах нь зүйтэй гэж үзсэн

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 6 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс орон нутгийн нэгтгэлд 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 төсвийн шууд захирагч, 2 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	1	28.0							1	28.0
		1	28.0							1	28.0

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 832.5 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өглөө.

1.1. Албан шаардлага:

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 643,461.9 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 189,163.2 мянган төгрөгийн 19 мэдээлэл байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тэс Засаг дарга	1	832.5					1	832.5
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	832.5					1	832.5

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

[Signature] М.МӨНХТОГТОХ/

2026 оны 03 сарын 25-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 01/65/А2070415
УВА-2026/004/НН-СТА-ТТЗ

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 643,461.9 мянган төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 189,163.2 мянган төгрөгийн 19 мэдээлэл байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн шаардах нь

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөн ажиллаж биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэс сумын Засаг дарга Г.Буяндалай, санхүү албаны дарга Ц.Энхбаяр нарт хариуцуулав.

3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.МӨНХТОГТОХ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ

